

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
2026 оны I улирал

2026 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
<i>ЗГ-ын албан даалгавар</i>							
1	1	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр , өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, 2025 оны жилийн эцсийн байдлаар нөхөн томилгоо хийгдээгүй болно. 2026 оны 3 дугаар сарны 31-ны байдлаар зайлшгүй шаардлагатай албан тушаалд 3 хүн томилон ажиллаж байна. Батлагдсан бүтэц, орон тоог хэтрүүлэхгүй хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.	100		
	2		1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	Ёс зүйн дэд хороо нь 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 15 арга хэмжээтэйгээр төлөвлөн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ёс зүйн дэд хороонд 2026 оны 03 дугаар сард албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 1 өргөдөл, гомдол мэдээлэл ирснийг холбогдох хууль дүрмийн дагуу шийдвэрлэсэн	100		

2	3		1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	2025 оны 05 дугаар сарын 02-ний А/14 дүгээр тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулсан.	100		
	4		1.7.. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;	Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөх, халах тушаал, шийдвэр гаргаагүй хууль, тогтоомжийн дагуу ажиллаж байна. Батлагдсан бүтцийн дагуу хүний нөөцийг бүрдүүлэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанарт тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх ажлын хүрээнд шинээр томилогдсон ажилтан, алба хаагчдад сургалт хийх зохион байгуулах , дадлагажуулан мэргэшүүлэх ажлыг тухайн бүр хэрэгжүүлж ажиллаж байна.	100		
	5	Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь	3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба”-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 09 өдрийн №А/07дугаартай тушаалаар Цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлуулж мөрдөн ажиллав. Тус өдрүүдэд байгууллагын үйл ажиллагаа, эд хөрөнгөд ямар нэгн ноцтой зөрчил дутагдал гараагүй болно.	100		

	6	нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах "Хариуцлагатай шуурхай алба" ажиллуулах тухай 2026-02-11 Дугаар 2026_01	4.Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 09 өдрийн №А/07дугаартай тушаалаар Цагаан сарын баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүр Нийслэлийн ерөнхий эргүүлд цагийн байдлыг тухай бүр илтгэн ажилласан.	100		
4	7	Онцгой нөхцөл байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай 2026-03-04	2.1.. 2.Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов: 2.1.Албан даалгаврын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, нарийвчилсан төлөвлөгөө гарган арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллах, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	Дээд газар болон Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн албан даалгавар, чиг үүрэг, зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж тайлан мэдээг заасан хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	100		
	8	Дугаар 2026_03	2.2. Ажлын хариуцлага алдсан, холбогдох үндэслэл тооцоо, судалгааг муу хийж, алдаатай шийдвэр гаргасан албан тушаалтанд тухай бүр нь хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлж ажиллах;	Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар хариуцлага алдсан, алдаатай шийдвэр гаргасан ажилтан, албан хаагч байхгүй байна.	100		

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТОГТООЛ ШИЙДВЭР, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Р.СОЛОНГО